

**БАЯНХОНГОР АЙМГИЙН 2025 ОНЫ БОДЛОГЫН  
БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙН  
ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2026 оны 04 дүгээр сарын 10

Номгон

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 онд бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, Засгийн газрын 2025 оны 183 дугаар тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”-ыг тус тус удирдлага болгон хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийн үр дүнгийн талаар орон нутгийн удирдлагууд, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрыг үнэн зөв, бодитой мэдээллээр хангаж, [www.unelgee.gov.mn](http://www.unelgee.gov.mn) цахим санд байршуулж, ил тод байдлыг ханган ажилласан.

Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт тайлагнасан бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээ болон Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайланг хоёр бүлэг болгон танилцуулж байна.

**Нэгдүгээр бүлэг: Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт тайлагнасан бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ:**

Баянхонгор аймгийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд дүгнэлт, илтгэх хуудсыг тайлан тус бүрээр хүргүүлсэн болно.

**1.1.Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:**

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд 2025 оны эхний хагас жил, 2025 оны жилийн эцсийн байдлаар 2 удаа хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын цахим системээр хугацаанд нь тайлагнасан байна.

Хэрэгжилтийн дэлгэрэнгүй товчоог хүснэгтэд үзүүлэв.

Д/д	Тайлагнасан хугацаа	Хяналтад авсан арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь	
			Үнэлгээ	Өссөн дүнгээр
1	2	3	4	5
1	2025 оны хагас жил	103	76.46%	77.03%
2	2025 оны жилийн эцэс	103	78.19%	77.53%

**1.2.Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:**

Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/6 дугаар тогтоолоор батлагдсан "Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн 8 бүлэг, 8 зорилго, 24 зорилт, 105 ажил арга хэмжээтэй батлан хэрэгжүүлж ажилласан бөгөөд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ үнэлгээ хийж хэрэгжилтийн дундаж 93.71 хувь байна.

**Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт (Үндсэн 8 бодлого хэрэгжилтийн хувиар)**

Д/д	Бодлого/ Зорилго	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь				Дундаж үнэлгээ (%)
				Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлэх шаардлагатай	Үр дүнгүй	
				100	70-90	30-50	0-30	
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	2	8	2	6	-	-	90%
2	Хүний хөгжил	5	31	22	9	-	-	97.09%
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	4	12	8	4	-	-	91.67%
4	Эдийн засаг	3	14	8	5	1	-	91.43%
5	Засаглал	2	8	5	3	-	-	93.75%
6	Ногоон хөгжил	3	11	11	-	-	-	100%
7	Амар тайван, аюулгүй орчин	3	8	3	5	-	-	86.25%
8	Орон нутгийн хөгжил	2	13	6	7	-	-	91.54%
<b>Нийт</b>		<b>24</b>	<b>105</b>	<b>65</b>	<b>39</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>93.71%</b>

**1.3.Баянхонгор аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:**

Баянхонгор аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 4 бодлогын хүрээнд 7 зорилго, 29 зорилт, 131 хөтөлбөр, үйл ажиллагааг төлөвлөсөн. Тус үйл ажиллагааны хөтөлбөрийн 2025 оны хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийхэд ТЕЗ-ийн үр дүн 68.57 хувь, хөтөлбөрийн үр дүн 81.81 хувь,


хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 76.18 хувьтай хэрэгжсэн байна.

#### **1.4.Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:**

Аймгийн 2025 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 4/27 дугаар тогтоолоор салбарын 25, төсвийн ерөнхийлөн захирагчийн 32, хөтөлбөрийн 39 үр дүнгийн хүрээнд 178 үндсэн үйл ажиллагаа, төсөл арга хэмжээг батлуулж боловсруулан 86.27 хувийн гүйцэтгэлтэй байна.

График. Үндсэн үйл ажиллагаа, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт

**Үндсэн үйл ажиллагаа, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт**



Цаашид аймгийн хөгжлийн төлөвлөгөөний арга хэмжээ, үйл ажиллагааны гүйцэтгэлийг ирүүлэхдээ аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 9/58 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт "Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ үнэлгээний шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин"-ний үр дүнг тайлагнаж хэвших зөвлөмжийг өгсөн.

#### **1.5.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний тойм:**

Монгол Улсын Хууль, Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын Байнгын Хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэр, Ерөнхий сайдын албан даалгаврын хэрэгжилтийг дүгнэн тогтоол шийдвэрийг орон нутагт үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлэх, хэрэгжилт үр дүнгийн талаар аймгийн удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор 2025 онд 10 удаагийн тайланг <http://new.unelgee.gov.mn> цахим системээр тайлагналаа.

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим санд хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр үүрэг чиглэл болгосон 161 хууль тогтоомжийн 308 заалтын биелэлтэд хяналт шинжилгээ хийхэд хэрэгжилтийн дундаж 96.0 хувь байна.

Хэрэгжилт гаргах нийт заалтын тоо		308
Хэрэгжсэн	Хэрэгжсэн - 100%	257
Хэрэгжих шатанд	Ахиц гарсан - 50%	2
	Тодорхой үр дүнд хүрсэн - 50%	9
	Удаашралтай /эрчимжүүлэх шаардлагатай - 50%	3
Хэрэгжээгүй	Зохион байгуулалтаас - 0%	3
	Санхүү, хөрөнгө оруулалтаас - 0%	1
Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Х.Б	27
Хэрэгжих боломжгүй	Хэрэгжүүлэх хугацаа тодорхойгүй	1
	Хэрэгжүүлэх чиг үүрэг тодорхойгүй	2
	Хэрэгжүүлэх зардал, санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй	1
	Хийгдэх үйл ажиллагаа, зорилго тодорхойгүй	2
	Хэмжигдэхүйц биш	-
<b>Хэрэгжилтийн дундаж</b>		<b>96.0%</b>

Хяналт шинжилгээний дүнгээр хэрэгжилтийг тооцох боломжгүй 27 арга хэмжээ, хэрэгжээгүй 4 арга хэмжээ байна.

### 1.6.Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тойм:

Баянхонгор аймагт хэрэгжиж байгаа Гадаадын 11 төсөл, хөтөлбөрийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 96.25 хувьтай дүгнэгдлээ.

Үнэлгээг хүснэгтэд нэгтгэвэл:

Д/д	Төсөл хөтөлбөр	Хэрэгжиж буй сумдын тоо	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4
1	"Тэгш хүртээмжтэй цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь" төсөл	1	100%
2	"Эх хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөр" 100-Child Survival and Development төсөл	2	70%
3	"Сэргийлж болох эх нярайн эндэгдлийг бууруулах нь" төсөл	2	100%
4	"Хамтарсан багийн гишүүдийн айл өрхөд үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх, тараах 6-10 насны хүүхэдтэй эцэг эхчүүдэд зориулсан мэдээллийн багц боловсруулах" төсөл	20	100%
5	"Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь" төсөл	2	100%
6	Тогтвортой байдлын төлөө Баянхонгор аймгийн бие даасан хоршоод бий болгох "GOATS буюу ЯМАА" төсөл	3	100%

1	2	3	4
7	"WIFI буюу Монголын нүүдлийн бэлчээрийн мал аж ахуйд түшиглэсэн чанартай, орон нутгийн махны үйлдвэрлэлийг хөгжүүлэх" төсөл	4	100%
8	"Халдварт өвчний дэгдэлтийг тогтвортой хянахад дэмжлэг үзүүлэх EPIC" төсөл	1	100%
9	"Хангайн бүсийн уулын ландшафтыг нөхөн сэргээж, хамгаалах замаар экосистемийн үйлчилгээ болон орон нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах нь" төсөл 2025-2030 он	1	ХБ
10	"Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох" төсөл	1	ХБ
11	"Цахим хоршоо" төсөл	2	ХБ

**1.7.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тойм:**

Баянхонгор аймгийн Засаг даргын 2025 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 19 гэрээний 892 заалтын хэрэгжилтийг 35 байгууллага тайлагнахаас 33 байгууллага ирүүлж, гэрээний заалтыг 97,8%, хавсралтын заалтыг 97,03%-тай тайлагнасан.


Баянхонгор аймгийн Засаг даргын 2025 онд орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх 19 гэрээний 892 заалтын хэрэгжилтийг [new.unelgee.gov.mn](http://new.unelgee.gov.mn) цахим санд хугацаанд нь 2026 оны 03 дугаар сарын 01-ний өдөр тайлагнаж баталгаажуулсан.

Аймгийн Засаг даргын Засгийн газрын гишүүдтэй байгуулсан 2026 оны 19 салбарын гэрээг pdf файлаар хүлээн авч word файл руу хөрвүүлэн 19 сайдын гэрээний заалтыг [new.unelgee.gov.mn](http://new.unelgee.gov.mn) цахим системд байршуулсан.

**1.8.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлт тогтоох, тайлан гаргах журам", Засгийн газрын 2025 оны "Журам батлах тухай" 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын "Аргачлал, загвар батлах тухай" 2020 оны 100 дугаар тушаалын дагуу 13 зорилтын хүрээнд 73 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн, баталсан байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 73 арга хэмжээний биелэлтийн дундаж 90.41 хувьтай байна



**1.9. Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг хангах үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:**

Баянхонгор аймаг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” хуулийг хэрэгжүүлж, төрийн байгууллагын ил тод, нээлттэй байхаар заасан 5 бүлгийн 46 төрлийн 98 үзүүлэлтээр аймгийн албан ёсны [www.bayanhongor.gov.mn](http://www.bayanhongor.gov.mn) болон 20 сумын албан ёсны цахим хуудсанд байршуулан хөгжүүлж ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 20 сумын Засаг даргын Тамгын газар, 24 агентлаг, 11 төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хянан үзэхэд дундаж үнэлгээ 67.32 хувьтай байна.

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийн тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний [new.unelgee.gov.mn](http://new.unelgee.gov.mn) цахим системд байршуулан, хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд 45 үзүүлэлт бүрэн хэрэгжсэн, 1 үзүүлэлт хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй үнэлэгдсэн.

Нээлттэй мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн үнэлгээг аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сангаар ирүүлсэн тайланд үндэслэн хийхэд босоо удирдлагатай байгууллагын хувьд бие даасан албан ёсны цахим хуудас байхгүй, дээд шатны байгууллагын цахим хуудсанд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагуудын мэдээллийг байршуулдаггүй, Төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагууд албан ёсны цахим хуудас хийлгэхэд санхүүгийн хувьд бэрхшээлтэй зэрэг хүндрэлтэй асуудал хэвээр байна.

Цаашид “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-д заасан 5 төрлийн 46 үзүүлэлт тус бүрийн мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас, ил тод байдлын самбар, бусад сувгуудаар байнга мэдээлж, шинэчилж, тухайн асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл авах эх сурвалж, холбоо барих ажилтны

мэдээллийг бүрэн байршуулж, нотлох баримт (цахим хуудасны холбоос, мэдээллийн самбарын зураг, бусад сувгуудаар мэдээллэсэн тухай баримт)-г хавсаргаж тайлагнах тухай зөвлөмжийг хүргүүлсэн.

**1.10.Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:**

Аймгийн хүний нөөцийн хөгжлийн бодлого нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн стратеги төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт орсон хүний нөөцийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх нэгдсэн хөтөлбөр болон нутгийн захиргааны байгууллагуудын бусад хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдан хэрэгжиж байна.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт 92.15 хувьтай байна.

**1.11.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийг биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тойм:**

Тайланд тусгагдсанаар Баянхонгор аймаг нь 2025 онд 150,000 ширхэг модыг тарьж, ургалтын хувийг 71%-д хүргэх зорилт тавьсан бөгөөд 266796 ширхэг мод, бут, сөөгийг тарьж, ургалтын хувийг 78,8%-д хүргэсэн байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой "Тэрбум мод" төсөл, арга хэмжээний 2025 оны хэрэгжилтийг 100% буюу "Үр дүнтэй" гэж дүгнэв. Онцлог ажлуудаас дурдвал:

1.Өнгөрсөн онд 2022-2025 онуудад 20 сумдын хэмжээнд тарьсан бүх модыг тоолох, ургалтын хувийг тогтоох ажлыг зохион байгуулсан нь үр дүнтэй арга хэмжээ болсон.

2.Орон нутгийн хөрсөнд дасан зохицсон тарьц суулгацыг үржүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд 6 сумын нутаг дэвсгэрт 7 үржүүлгийн газар 6\*20, 10\*4, 3\*6, 4\*3, 6\*10, 2\*120-н хэмжээтэй 18 ширхэг хүлэмжийн 2194м<sup>2</sup> талбайд 14 төрлийн мод үрээр, 5 төрлийн мод мөчрөөр 6494 м<sup>2</sup> талбайд тарьж, нийт 15185 м<sup>2</sup> талбайд 74 кг үр, 303900 ширхэг мөчир шинээр үржүүлэн бойжуулж байна.

3. Ховд аймгийн Булган сумын Минжит булган жимс, жимсгэнийн аж ахуйтай хамтран Монголын эрс тэс уур амьсгалд тэсвэртэй, өндөр ургац өгдөг бэсрэг алим, өрөл, чавга жимсийг тариалахаар 300 ширхэг алим, 100 ширхэг чавга, 6 ширхэг өрөл нийт 406 ширхэгийг авчирч, тариалалтыг хийсэн нь тус аймагт жимсний аж ахуйн эхлэл тавигдсан шинэлэг ажил болсон байна.

4.Өлзийт сумд 300 га, Эрдэнэцогт сумд 7000 га, Галуут сумд 3500 га, Жаргалант сумд 2000 га нийт 12300 га талбайд Ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулж, тэмцлийн ажлын дараах судалгаагаар ойн хөнөөлт шавжийн тархалт 6605 га-д голомт илрээгүй нь модыг хортон шавжид өртөх, ургах чадвараа алдахаас хамгаалж чадсан зэрэг үр дүнтэй ажлууд хийгджээ.

**Хог хаягдлын менежмент:**

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 02 дугаар албан даалгавар, аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар албан даалгавар, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 131 дүгээр тогтоолоор батлагдсан "Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой "Хог хаягдал" төсөл, арга хэмжээний 2025 оны хэрэгжилтийг 100% буюу "Үр дүнтэй" гэж дүгнэв.

Хог хаягдлын тухай хуулийн 9.2.1, 9.2.2-т заасан нэгж тариф, үйлчилгээний хураамжийн хэмжээг 20 сум ИТХ-аараа хэлэлцэн тогтоосон байна.

Мөн хуулийн 17.6 дахь заалтад заасан хатуу хог хаягдлын цэгийг 3 зэрэглэлд нийцүүлэх шаардлагыг Баянлиг, Баянговь, Бөмбөгөр, Баянбулаг, Өлзийт, Баян-Өндөр, Баянцагаан, Шинэжинст, Жаргалант, Богд, Баян-Овоо, Галуут, Гурванбулаг, Бууцагаан сумд бүрэн хангасан. Жинст, Заг, Хүрээмарал, Баацагаан, Эрдэнэцогт сумууд хагас хангаж хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайг 12.38 га талбайгаар багассан байна.

Тайлант онд нийт хог хаягдлын 1,5%-ийг, 2026 онд 8 төрлөөр нийт хог хаягдлын 3%-ийг дахин боловсруулж байгаа нь өмнөх оноос 1.5%-иар өссөн үзүүлэлттэй байна.

Мөн тээвэрлэсэн энгийн хатуу хог хаягдлын хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3145.4тн-оор буурсан.

**Цахим шилжилт:**

Хяналт шинжилгээ, үнэлгээгээр Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой "Цахим" төсөл, арга хэмжээний 2025 оны хэрэгжилтийг 80% буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж дүгнэв. Цахимжилтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Сум бүрийг төрийн үйлчилгээний ТҮЦ машинаар хангах зорилт тавьж, улсын төсвийн хөрөнгөөр аймгийн 20 сум төрийн үйлчилгээний GEREGE киоск машинтай болсноор хагас жилд 27,400 гаруй иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан байна.

Нэгдсэн тайлан, илтгэх хуудсыг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

**1.12.Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тойм:**

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн гүйцэтгэлийг 90,58%-ийн үнэлгээтэйгээр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт цагалварт хугацаанд хүргүүлсэн.

**1.13.Зөвлөмжийн хэрэгжилт:**

Монгол Улсын Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын 2025 оны 02/736 дугаар албан бичгээр ирүүлсэн аймгийн 2024 оны жилийн эцсийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, удаашралтай заалт арга хэмжээний хэрэгжилтийг дунджаар 82.5 хувьд хүргэн эрчимжүүлж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилтийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн 8/1281 тоот албан бичгээр хүргүүлсэн болно.

**Хоёрдугаар бүлэг:Нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ:**

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг сумын Засаг даргын Тамгын газар, орон нутгийн өмчийн байгууллагуудын 2024, 2025 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажилласан ба албан хаагчдыг чадавхжуулах хяналт-шинжилгээ, үнэлгээний ил тод байдлыг хангах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

2.1 Аймгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний <http://bayankhongor.igovernment.mn> цахим системээр дараах 16 төрлийн тайланг 20 сум, 24 агентлаг, 11 төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газрын 7 нэгжээс авах нөхцөлийг бүрдүүлж, давхардсан тоогоор 651 байгууллага, нэгжид 5012 бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн заалтыг хуваарилж, 58143 заалтын хэрэгжилтэд 49 удаагийн давтамжтайгаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгч ажилласан байна. Үүнд:

Д/д	Тайлагнасан баримт бичгийн нэр	Тайлагнасан байгууллага, АЗДТГ-ын нэгжийн тоо	Хяналтад байгаа		Үнэлгээ	ХШҮ хийсэн заалтын тоо
			Шийдвэрийн тоо	Заалтын тоо		
1	2	3	4	5	6	7
1	Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан	12	1	103	2	206
2	Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлийн тайлан	35	1	105	1	105

1	2	3	4	5	6	7
3	Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан	1	1	299	2	598
4	Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан	20	20	2039	2	4078
5	Дэд хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайлан	61	78	289	2	578
6	Хууль Тогтоомж, тогтоол шийдвэр	62	1344	2795	18	22360
7	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт	62	149	152	2	304
8	Аймгийн Засаг даргын захирамж, албан даалгаврын хэрэгжилт	62	3308	5772	4	5772
9	Засгийн газрын гишүүн-Засаг даргатай байгуулсан гэрээ. (Засгийн газрын зарим чиг үүргийн орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө)-ний хэрэгжилт	35	19	1543	2	3086
10	Аймгийн Засаг дарга Сумын Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт	20	20	2765	2	5530
11	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	55	55	3262	2	6524
12	Сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хөтөлбөрийн хэрэгжилт	55	1	378	2	756
13	Ил тод байдлын шалгуурын тайлан	55	1	2530	2	5060
14	Зөвлөмжийн хэрэгжилт	61	8	732	2	1464
15	Байгууллагын тэргүүлэх чиглэлийн шалгуур үзүүлэлтийн тайлан	35	1	161	2	322
16	Сумдын орон нутгийн хөгжлийн сангийн тайлан	20	1	35	2	1400
	Дүн	651	5012	20445	49	58143

Дээрх цахим тайлангаас гадна харьяа байгууллага, сумдаас ирүүлсэн Аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, Монгол Улсын Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлтийг цаасаар хүлээн авч үнэлж ажиллалаа.

2.2. Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн хэрэгжилт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны баримт бичгүүдийн төлөвлөлт, зохион байгуулалт, хэрэгжилт тайлагналтад явцын хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, бодлогын зөвлөмж, мэргэжил арга зүйгээр хангах, ажилтнуудын ур чадвар, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх зорилгын хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газрын

даргын баталсан 2025 оны 03, 04, 44, 66 тоот удирдамжаар сумдын төрийн байгууллагууд, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагаанд явцын Хяналт шинжилгээ, үнэлгээ, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж ажилласан.

Дээрх ажлын хүрээнд дараах томоохон ажил болох:

- Төрийн албаны тухай хуулийн 53.1-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна”,
- Сумдын “Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” батлагдаагүй,
- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг мөрдөөгүй зэргийг анхааруулж ажиллалаа.

Үүний үр дүнд 20 сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, бодлогын хэрэгжилтийг хэмжих, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх зохион байгуулалтын суурийг бүрдүүлж чадсан байна.

2.3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар ахлуулсан удирдлагын багаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын болон сумдын Засаг даргын Тамгын газар, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, ажлын гүйцэтгэлийн явцыг үнэлэх зорилгоор ажлын тайланг хэлэлцүүлж, өнөөгийн нөхцөл байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар чиглэл өгч ажилласан нь үнэлгээний дүнд эерэг нөлөө үзүүлсэн байна.

2.4. Тайлант оны 5 дугаар сарын 21-ний өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн дунд “Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, тайлагналт, цаашид авах арга хэмжээ”-ний талаарх хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

2.5. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газар, Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын 2025 оны эхний хагас жил, жилийн эцсийн бодлогын баримт бичиг, хууль, тогтоомж, тогтоол шийдвэр, байгууллагын үйл ажиллагааны тайланд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмж, тайланг байгууллага тус бүрт хүргүүлэн, хэрэгжилтийг тооцон ажилласан.

**Дүгнэлт:**

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газраас 2025 онд сум, харьяа байгууллагын үйл ажиллагаанд 4 удаа зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 2 удаагийн сургалт зохион байгуулж, 20 сум, 24 агентлаг, 11 төрийн болон орон нутгийн өмчийн байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газрын 7 нэгжийн 19 төрлийн бодлогын баримт бичиг, давхардсан тоогоор 70 баримт бичгийн 5016 тайлангийн 58629 заалт арга хэмжээний гүйцэтгэлийн явц, үр дүнд 49 удаагийн давтамжтайгаар хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр хангаж ажилласан байна.

Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх явцад байгууллага дахь гүйцэтгэлийн удирдлага хангалтгүй, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг холбогдох албан тушаалтан гаргаж байгаа хэдий ч түүнийг уншдаг, хянадаг, засварладаг, зөрүүг арилгадаг ажил хэрэгч байдал алдагдаж “Тайланг хянасан, Тайлантай танилцсан гэх мэт” тайлал харагддаг ч бодит байдал дээр танилцахгүйгээр баталгаажуулах тохиолдол гарч байна.

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх, хөтөлбөрийн агуулгад шинэ ажилтанг сургаж, хөгжүүлэх чиглэлээр заалт оруулах, Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний мэдлэг ур чадварын зорилтыг бодитой болгох нь чухал байна.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”. Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2025 оны “Төрийн байгууллагад эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх тухай” 03 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн байгууллагын эрсдэлийн удирдлагын бодлого”-ыг хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

ТАНИЛЦСАН:  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
МЭРГЭЖИЛТЭН



Э.ЭНХБАТ

Т.ЭРДЭНЭБАТ

Э.МӨНХТУЯА

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН**

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт	96	0.5	
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	77.53		
	3.Аймаг, нийслэлийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	86.27		
	4.Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	76.18		
	5.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт	90.58		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1.Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	97.8	0.15	4.53
	2.Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	90.41		
	3.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилт	92.15		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдал	100	0.2	
	2. Шилэн дансны хөтлөлт	-		
	3. Шударга байдлын түвшин	-		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	-		
Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээ	Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл арга хэмжээг үнэлэх шалгуур үзүүлэлтийн биелэлт	100	0.15	
Ерөнхий үнэлгээ:		90.69	0.91	

ТАНИЛЦСАН:  
БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГА

Э.ЭНХБАТ

ДҮНГ НЭГТГЭСЭН:  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ЭРДЭНЭБАТ

